

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2018 онд Ган хийц ХК-ийн үндсэн үйлдвэрлэл дараах чиглэлүүдээр явагдсан. Үүнд:

- Төмөр хийц эдлэл үйлдвэрлэл
- Барилга угсралт

Ган хийц ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал, ЗАА зардлын төсөв, борлуулалтын хэмжээг дараах байдлаар баталж өгсөн байна.

№	Нэр	Төсөв
1	ТУЗ-ийн зардал	118 752 000
2	ЗАА зардал	5551719560
3	Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралтын борлуулалт	2 270 957 000

Материал татан авалтыг боловсронгуй болгож, материал байнгын авдаг харилцагчтай болох. Өмнөх жилүүдэд томоохон ажлын материалыг Эрээн хотоос авдаг байсныг үргэлжлүүлэх болно.

2018 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна

Захиалагч	Ажлын нэр	Хаана хийсэн	Хугацаа	Үнэ
Ган эрдэнэ констракшн ХХК	22x23x10-11м 7x14x5-5,5м төмөр хийц	СХД, 7 хороо	2018.04.09- нөөс ажлын 21 хоног	174 240 000
“Жи Си Ар монголиа” ХХК	Сэндвичэн барилгын төмөр хийц угсрах	Хан уул дүүрэг 15 хороо шинэ мянганы барилга 5 давхар	2018.06.09- нөөс ажлын 10 хоног	75 648 996
Дорнод аймгийн ЗДТГ барилга	Засаг даргын тамгын газар	Дорнод аймаг	2011-2018	627 650 454

УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Хараат бус гишүүн П.Төвсанаа өөрийн хүсэлтийн дагуу чөлөөлөгдөж, 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Цэвэгсүрэн овогтой Жанлавийг сонгож томилсон.

Орон тоо бүтцийн талаар:

2018 оны ТУЗ болон Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн төсвийг дараах байдлаар баталсан.

№		Төсөв
1	Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	363 034 560
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	51 600 000

Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс www.gankhiits.mn веб сайт шинэчлэгдэж, Хувьцаа эзэмшигчдэд зориулан булан гаргасан бөгөөд компанийн холбогдолтой бүхий л мэдээллийг авах боломжтой юм.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2018 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсралт-1-ээр үзүүлэв.

НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгж хувьцаанд 100 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.

Уг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан бөгөөд одоогийн байдлаар ногдол ашгийг тарааж эхлээгүй байна.